Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 80,681,850.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 806,818.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,799,186.5 мянган төгрөгөөр буюу 407.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	1,726,175.3	6,151,739.3	4,425,564.0
Авлага	405,572.0	2,452,953.3	2,047,381.3
Бараа материал	17,384.3	17,272.8	(111.5)
Үндсэн хөрөнгө	257,701.3	1,177,221.1	919,519.7
Нийт хөрөнгийн дүн	2,406,833.0	9,799,186.5	7,392,353.5
Богино хугацаат өр төлбөр	88,386.5	187,189.8	98,803.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,318,446.5	9,611,996.7	7,293,550.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,406,833.0	9,799,186.5	7,392,353.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,151,739.3 мянган төгрөг болж, 4,425,564.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд олгох тэтгэвэр, тэтгэмж нь батлагдсан төсвөөс илүү байснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 2,452,953.3 мянган төгрөг болж 2,047,381.3 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 1,2 дугаар зүйлд заасан ажил олгогч, сайн дурын даатгуулагчийн чөлөөлөлт, ажил олгогчид олгосон дэмжлэгээр улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлага, ажил олгогчоос авах НДШ-ийн авлага, тэтгэмж, төлбөрийг илүү шилжүүлснээс тус тус шалтгаалжээ.

Нийт авлагын 2014-2019 оны хооронд үүссэн 19,484.4 сая төгрөгийн тайлант хугацаанд төлөлт ногдуулалт хийгдээгүй хэвийн бус авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17,272.8 мянган төгрөг болж 111.5 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагаанд зарцуулсан бусад хангамжийн материалын зарцуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,177,221.1 мянган төгрөг болж 919.5 мянган төгрөгөөр өссөн нь шинэ барилга ашиглалтад орж, НДЕГ-аас машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил балансаас балансын хооронд шилжүүлэн авсанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 187,189.8 мянган төгрөг болж 98,803.3 мянган төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний бусад зардлын өглөг, урьдчилж орсон орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 9,611,996.7 мянган төгрөг болж 7,293,550.2 мянган төгрөгөөр өссөн тайлант онд 7,230,086.2 мянган төгрөгийн үр дүнтэй ажилласнаас шалтгаалжээ. 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,293,423.9 мянган төгрөгөөр буюу 25.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс банкны хүүгийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь төсөвт байгууллагын арилжааны банкнууд дахь сангуудын харилцах дансны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 20,070.8 мянган төгрөгөөр буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас хяналт шалгалт хийгдээгүйгээс акт төлбөр, алданги, торгуулийн авлага 17,130.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,751,774.4 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,488,079.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зарлагыг 39,564,355.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс санхүүжүүлэх эх үүсвэрийн төвлөрүүлэх орлогыг 319,895.5 мянган төгрөгөөр бууруулж, 17,807,974.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 10,162,949.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 49,727,304.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн, 89 арга хэмжээг санхүүжүүлэхээр 49,727,304.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 49,727,304.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 17,807,974.5 мянган төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 14,866.5 мянган төгрөг, нийт 17,822,841.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бусад эх үүсвэрээс 31,335,841.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, сангууд болон урсгал үйл ажиллагаанд 49,158,682.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 49,158,682.9 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 17,745.6 мянган төгрөг буюу 96.2 хувь, ажил олгогчийн НДШ 6,403.9 мянган төгрөг буюу 89.8 хувь, байр

ашиглалттай холбоотой зардал 6,228.5 мянган төгрөг буюу 84.1 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2,887.5 мянган төгрөг буюу 89.7 хувь, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 535,176.3 мянган төгрөг буюу 98.9 хувиар төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2020 онд 13,715,755.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 17,822,840.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 129.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Аж ахуй нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	1,035,718.5	1,540,895.2	(505,176.7)	148.8
Даатгуулагчийн төлөх шимтгэл	5,131,747.6	5,511,904.1	(380,156.5)	107.4
Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	5,007,623.7	5,040,186.8	(32,563.1)	100.7
Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэл	65,405.6	35,542.5	29,863.1	54.3
Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэл	237,108.2	34,650.0	202,458.2	14.6
Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөн төлөх шимтгэл	1,252,843.2	2,986,704.0	(1,733,860.8)	238.4
Сайн дурын даатгуулагчдын төлөх шимтгэл	960,332.5	2,566,908.1	(1,606,575.6)	267.3
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	16,034.1	17,421.6	(1,387.5)	108.7
Бусад орлого	8,942.2	88,628.6	(79,686.4)	991.1
<b>ДҮН</b>	<b>13,715,755.6</b>	<b>17,822,840.9</b>	<b>(4,107,085.3)</b>	<b>129.9</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2020 оны нэгтгэсэн тайлан.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НДЕГ-аас 3,783.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 3,286.0 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 497.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэлгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас нийт 12 мэдээллийг хугацаа хожимдуулж, өмч хөрөнгө захиран зарцуулах 10 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай

хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус дагаж мөрдөөгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаж орсон 5 албан хаагчийн ажилгүй байх хугацааны нийт 35,435.0 мянган төгрөгийн цалинг байгууллагаас нөхөн төлж хохирлыг барагдуулсан тухай НДЕГ-т хүргүүлсэн 1 албан шаардлагаас бусдыг нь бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			/мян.төг/ Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн
Төлбөрийн акт	2	8,357.5	2	8,357.5	100.0	-	-
Албан шаардлага	2	474,197.8	1	438,762.8	92.5	1	35,435.0
Зөвлөмж	6	6,841.5	6	6,841.5	100.0	-	-
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>489,396.8</b>	<b>9</b>	<b>453,961.8</b>	<b>97.5</b>	<b>1</b>	<b>35,435.0</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 315,059.1 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 946.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 47,011.6 мянган төгрөгийн 5 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 247,101.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн 69,122.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг дараах байдлаар шийдвэрлэлээ. Үүнд:

1. Цалингийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримтруу хөөн шалгахад Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2 дахь заалтыг зөрчин нэр бүхий албан хаагчдад томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгө давхардуулан олгосон байна. Энэ нь үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолттой ажиллах хугацаанд цалинг зөрүүтэй тооцож олгосон тул улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. Цалингийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу хөөн шалгахад Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн, өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, цалингийн зардлаас дарга Ц.Энх-Амгаланд 2019 оны үр дүнгийн урамшуулал 326.6 мянган төгрөгийг олгосон байна. Мөн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр

зүйлийн 40.4.2 дахь заалтыг зөрчин аймгийн Засаг дарга албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн 2020 оны Б/47 дугаар захирамжаар 2020 оны үр дүнгийн урамшууллыг 40 хувь буюу 435.5 мянган төгрөгийг олгосон байхад НДЕГ-ын даргын 2020 оны Б/170 тушаалаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн 100 хувиар үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг зөрүүтэй тооцож олгосон тул улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

3. Нийгмийн даатгалын сангийн төрийн банкны болон ХААН банкны төвлөрсөн орлогын харилцах дансны 9,949.7 мянган төгрөгийн орлогын үлдэгдлийг сангуудад хуваарилаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4-т "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл /зарлагаас давсан орлого/-ийг тухайн сан тус бүрийн нийгмийн даатгалын төв байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Тухайн сангийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа сард шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын төв байгууллагаас зөвшөөрөл авна" гэсэн заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төвлөрсөн орлогын дансан дахь орлогыг холбогдох тогтоосон хувь хэмжээгээр сангуудад хуваарилдаггүй зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4. Албан томилолтын 2,456.8 мянган төгрөгийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримтруу хөөн шалгахад НДЕГ-аас тайлан тушаахад хуваарьт албан бичиг байхгүй, албан томилолтын хуудас хаагаагүй, 5 удаагийн томилолтоор ажиллахдаа илтгэх хуудсанд нэг ижил чиглэлийн ажил гүйцэтгэснээр илтгэсэн зэрэг зөрчлүүд байна. Энэ нь үнэн зөв байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5. Тээвэр шатахууны 9,707.0 мянган төгрөгийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу хөөн шалгахад НДҮЗ-ийн 2019 оны "2020 оны төсвийн хуварь батлах тухай" 10 дугаар тогтоол, НДЕГ-ын даргын "2020 оны төсвийн хуварь батлах тухай" А/02 дугаар тушаалыг зөрчин сумдын байцаагч нарт олгох батлагдсан тээвэр шатахууны зардлыг сар бүр олголгүй, хэлтсийн албаны хэрэгцээнд хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн НДЕГ-ын даргын 2020 оны 1/49 тоот албан тоотоор ирүүлсэн зөвлөмжийн 2.7 дахь заалтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэрэгжүүлдэггүй алдаа зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй НДЕГ-ын даргын 2019 оны А/117 дугаар тушаалын 4-р хавсралтаар баталсан "Сумын

нийгмийн даатгалын байцаагчид шатахууны зардал олгох журам"-ыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

6. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас нийт 12 мэдээллийг хугацаа хожимдуулж, өмч хөрөнгө захиран зарцуулах 9 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байгаа зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хуулийг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

7. 2020 онд бараа материалын тайлангаас 30,272.0 мянган төгрөгийн материалыг зарцуулахдаа НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шаардах хуудсаар зарцуулсан боловч, зөвшөөрөл олгосон эрх бүхий албан тушаалтны гарын үсэг байхгүй, шаардах хуудас үндэслэн зарлагын баримт үйлдээгүй зэргээс зарцуулалт нотлогдохгүй байна. Мөн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 246,882.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. 2014-2019 оны хооронд үүссэн 19,484.4 мянган төгрөгийн авлагад тайлант хугацаанд төлөлт, ногдуулалт хийгдээгүй хэвийн бус авлага байна. Иймд нийт авлагын насжилтыг шимтгэл төлөгч тус бүрээр авлагыг нарийвчлан үзэх, мөн төсвийн шууд захирагч үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг даргын шийдвэрээр авч байгаа асуудлыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх.
2. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байлаа. Иймд дээрх асуудлуудыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Балансын данстай холбоотой асуудал.

1.1 Илрүүлэлт: Байгууллагын эзэмшилд байгаа элэгдлээрээ анхны өртөгөөр нөхсөн үндсэн хөрөнгийн 4 дансны 37 нэр төрлийн 119,253.4 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох ажил зохион байгуулаагүй байна. Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.1, 7 дугаар зүйлийн 7.3.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2 Эрсдэл: Хөрөнгийн элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй, элэгдэл нь дууссан үндсэн хөрөнгийн их хэмжээний үлдэгдлийг актлаагүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2005 оны 233 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгийг ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын 7-д хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

##### 2. Балансын данстай холбоотой асуудал.

2.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд бусад авлага дансанд 90.5 сая, бусад өглөг дансанд 38.5 сая төгрөгийн нэр данс зөрүү, ташаарсан гүйлгээнүүд бүртгэсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үүссэн авлага, өглөг байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т “Нийгмийн даатгалын сан” гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг”, 4-т “нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг” гэж заасныг мөрдөөгүй, үнэн зөв байдал эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2 Эрсдэл: Найдваргүй авлага үүсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх,

2.3 Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй авлага үүсгэхгүй байх, дотоод хяналтыг сайжруулах, авлагыг дахин тодорхойлж үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авч ажиллах;

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

**3. Балансын данстай холбоотой асуудал.**

**3.1 Илрүүлэлт:** НДХ-ийн баталсан 2005 оны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн шинэчлээгүй, 2018 онд шинэчилсэн НДЕГ-аас боловсруулсан гаргасан НБББББ-ийг мөрдөж ажиллаж байгаа боловч баталгаажуулсан шийдвэр байхгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Эрсдэл:** Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх.

**3.3 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдэн мөрдөгдөж байгаа хууль, журамд нийцүүлэн шинэчлэх..

**3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

**4. Балансын данстай холбоотой асуудал.**

**4.1 Илрүүлэлт:** Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 18,809.8 мянган төгрөгийн НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь үнэн зөв байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2 Эрсдэл:** Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгох, Татварын орлого дутуу бүрдэх.

**4.3 Өгсөн зөвлөмж:** Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, Цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах.

**4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР Огноо: 2021/03/25  
Ж.ЭНХЦООДОЛ Огноо: 2021/03/25

**БЭЛТГЭСЭН:**  
АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ Огноо: 2021/03/25

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.03.25</b>	Аудитын нэр: <b>Нийгмийн даатгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>БУА-2021/19/СТА-ТТЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Булган аймгийн Нийгмийн даатгалын сан</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Нийгмийн даатгалын сангийн төрийн болон ХААН банкны төвлөрсөн орлогын харилцах дансны орлогын үлдэгдлийг сангуудад хуваарилаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4-т "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл /зарлагаас давсан орлого/-ийг тухайн сан тус бүрийн нийгмийн даатгалын төв байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Тухайн сангийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг дараа сард шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын төв байгууллагаас зөвшөөрөл авна" гэсэн заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.	9,949.7	Төвлөрсөн орлогын дансан дахь орлогыг холбогдох тогтоосон хувь хэмжээгээр сангуудад хуваарилдаггүй зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
2	Байгууллагын эзэмшилд байгаа элэгдлээрээ анхны өртөгөөр нөхсөн үндсэн хөрөнгийн 4 дансны 37 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох ажил зохион байгуулаагүй байна. Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.1, 7 дугаар зүйлийн 7.3.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	119,253.4	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж өглөө.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
3	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд бусад авлага дансанд 90.5 сая, бусад өглөг дансанд 38.5 сая төгрөгийн нэр данс зөрүү, ташаарсан гүйлгээнүүд бүртгэсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үүссэн авлага, өглөг байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т "Нийгмийн даатгалын сан" гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	129,038.2	Үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй үүссэн авлагыг дахин тодорхойлж авлагыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өглөө.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан

	<p>тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", 4-т "нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг" гэж заасныг мөрдөөгүй, үнэн зөв байдал эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.</p>				
4	<p>Цалингийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримтруу хөөн шалгахад Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол " Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2 дахь заалтыг зөрчин нэр бүхий албан хаагчдад томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгө давхардуулан олгосон байна. Энэ нь үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	184.0	<p>Албан томилолттой ажиллах хугацаанд цалинг зөрүүтэй тооцож олгосон тул улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.</p>	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
5	<p>Албан томилолтын зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримтруу хөөн шалгахад НДЕГ-аас тайлан тушаахад хуваарьт албан бичиг байхгүй, албан томилолтын хуудас хаагаагүй, 5 удаагийн томилолтоор ажиллахдаа илтгэх хуудсанд нэг ижил чиглэлийн ажил гүйцэтгэсэнээр илтгэсэн зөрчлүүд байна.</p>	2,456.8	<p>Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.</p>	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
6	<p>Цалингийн зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу хөөн шалгахад Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн, өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй цалингийн зардлаас дарга Ц.Энх-Амгаланд үр дүнгийн урамшуулал олгосон байна. Мөн НДЕГ-ын даргын 2020 оны Б/170 тушаалаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн олгосон үр дүнгийн урамшууллыг Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалтыг зөрчин аймгийн Засаг даргын захирамжаар 2020 оны Б/47 дугаар захирамжаар давхардуулан олгосон байна.</p>	762.1	<p>Цалинг зөрүүтэй тооцож олгосон тул улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.</p>	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
7	<p>Тээвэр шатахууны зардалд горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу хөөн шалгахад НДҮЗ-ийн 2019 оны "2020 оны төсвийн хуварь батлах тухай" 10 дугаар тогтоол, НДЕГ-ын даргын "2020 оны төсвийн хуваарь батлах тухай" А/02 дугаар тушаалыг зөрчин сумдын байцаагч нарт олгох батлагдсан тээвэр шатахууны зардлыг сар бүр олголгүй, хэлтсийн албаны хэрэгцээнд хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн НДЕГ-ын даргын 2020 оны 1/49 тоот</p>	4,333.1	<p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэрэгжүүлдэггүй алдаа зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй НДЕГ-ын даргын 2019 оны А/117 дугаар тушаалын 4-р хавсралтаар баталсан "Сумын нийгмийн даатгалын байцаагчид шатахууны зардал олгох журам"-ыг мөрдөж</p>	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан

	албан тоотой ирүүлсэн зөвлөмжийн 2.7 дахь заалтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй байна.		ажиллах албан шаардлага хүргүүлээ.		
8	НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6,13.7 дахь заалтуудыг зөрчин бараа материалын тайлангаас зарцуулалт хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй тул зарцуулалт нотлогдохгүй байна. Мөн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.	30,272.0	Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлээ.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
9	Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас нийт 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус дагаж мөрдөөгүй байна. Мөн өмч хөрөнгө захиран зарцуулах 9 шийдвэрийг мэдээлээгүй байна.	-	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
10	Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2018 онд шинэчлэн боловсруулсан НБББББ-ийг мөрдөж ажиллаж байгаа боловч баталгаажуулсан шийдвэр байхгүй байна. Мөн Нийгмийн даатгалын хэлтэс нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, өөрийн байгууллагын бодлогын бичиг баримт байхгүй байгаа нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.	-	НББ-ийн бодлогын бичиг баримтыг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
11	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хоригоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан	18,809.8	Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгох, Татварын орлого дутуу бүрдэх эрсдэлтэй тул Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, Цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хянах сайжруулан ажиллах зөвлөмж өглөө.	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан

<p><i>татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй"</i> заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь үнэн зөв байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>				
<p><b>ДҮН</b></p>	<p><b>315,059.1</b></p>			